

Ажлын хуудас 2

/ Унших /



Боловсруулсан багш: Я. Болортуяа

Алхам 1

Эхийг анхааралтай уншаарай



Бялзуухайн үүр



“ Бялзуухай үүр барих гэж байна ” гэсэн сүргийг барилгачин шаазгай сонсоод, тэднийд очжээ. Шаазгай үүр барих шинэ загвар хийж өгөөд “ Чи миний энэ загвараар үүрээ баривал бат бөх, сайхан гэртэй болно. Хэрэв чамд тусламж хэрэгтэй бол надад хэлээрэй ” гэжээ.

Бялзуухай ихэд баярлаж, “ Өнөөдөр бэлтгэлээ базаая. Та маргааш ирж надад үүр барихыг зааж өгөөч ” гэжээ.

Маргааш өглөө нь шаазгай бялзуухайгийн ирэв. Бялзуухай : “ Шаазгай эгч ээ, Уучлаарай. Өчигдөр тагтаа ахын хуриманд очоод юу ч бэлдэж амжсангүй. Та маргааш ирж болох уу? Би юмаа бэлдээд байж байя ” гэв.

Маргааш нь шаазгай бялзуухайгийн бас л ирэв. Бялзуухай түүнийг хараад: “ Эгч ээ, Ёстой муухай юм боллоо. Өчигдөр хөхөө эгчийн төрсөн өдөрт очоод юу ч бэлдэж чадсангүй. Та маргааш ирж туслаач ” гэж гүйжээ.

Маргааш нь шаазгай ирж явааг хараад бялзуухай сандран “ Үнэхээр эвгүй юм боллоо. Өчигдөр манайд шар шувуу ах ирж, бид хоёр хууч хөөрсөөр байгаад юу ч хийж чадсангүй. Та маргааш ирж чадах уу? ” гэжээ.

Шаазгай:

:

“ Маргааш! Маргааш! Чиний маргааш хэзээ ч дуусахгүй юм байна. Би дахин ирж чадахгүй. Чи өөрөө үүрээ барь! ” хэмээн ихэд хилэгнэн одов. Бялзуухай үүрээ барьж чадаагүй тул өнөөг хүртэл айлын байшингийн саравчинд толгой хоргодох болсон гэнэ.